Амжилттай хэрэгжсэн эрсдэлд суурилсан тогтолцоо нь мөн өсөлт, хөгжлийн саад бэрхшээлийг арилгахад дэмжлэг үзүүлж, салбар дах хууль журмыг дагаж мөрдөхөд учирч буй саад бэрхшээлийг бууруулдаг.

Эрсдэлд суурилсан тогтолцоог хэрэгжүүлэхэд техникийн, улс төрийн болон институцийн олон асуудлууд тулгардаг байна. Чухамдаа, эрсдлийн удирдлагыг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хэрэгсэл болгон ашиглах нь эрсдлийг тодорхойлох, эрсдлийн дүн шинжилгээ хийх, үнэлэх, анхаарал хандуулах хэсгийг тодорхойлох, эцэст нь эрсдлийг засах, дахин үнэлэх зэргийг багтаасан үйл явц юм.

Өндөр эрсдэлтэй анги, салбаруудад чиглэсэн сонголтот хяналт шалгалтын стратегийг үр дүнтэй хэрэгжүүлсэнээр байгууллагад зорилтоо хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын стратегийг амжилттай хэрэгжүүлэх гол цэг нь хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хяналт шалгалт хийх объектийг сонгох үйл ажиллагааг тусад нь авч үзэх шаардлагатай юм.

*ХСИС-ийн Хуулъ сахиулах удирдлагын*
*академийн 821 дүгээр дамжааны суралцагч,*
*хошууч Б.Мырзабек*

## ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

***Хураангүй.*** *Аюулгүй байдлыг олон талаар нь судлаж байсан бөгөөд сүүлийн үед аюулгүй байдлыг хангахад хүн нэг бүрийн аюулгүй байдал чухал гэж үзлэг ба байгууллагын аюулгүй байдлыг ямар нэгэн байдлаар судалсан судалгаа нэн ховор байна.*

***Түлхүүр*** *үг. Аюулгүй байдал, байгууллагын аюулгүй байдал, байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх хүчии зүйл.*

*Аюулгүй байдал гэж юу вэ?* Зорилго, судалгаа аль эсвэл өөр зүйлийг хэлэх үү? Аюулгүй байдал гэдэг нь судалгааны түвшнөөсөө хамааран харилцан адилгүй бүтэцтэй учраас нарийн тодорхойлоход бэрх. Ихэнхи судлаачид аюулгүй байдал гэдгийг түрэмгийлэлээс ангид байхаар хязгаарлаж ойлгодог. Германы судлаач Ричард Лоевэнтал уг нийтлэг ойлголт дээр нийгэм, улс төрийн хараат бус байдлыг хамруулсан бол Жосеф Най эдийн засгийн чиглэлийн нэмжээ.

Харин Ричард Уллман аюулгүй байдлыг дан ганц цэргийн аюул заналаар хязгаарлах нь бодит байдалтай нийцэхгүй гэж үзсэн. Тэрээр “Ард иргэдийн амьдралын түвшинг богино хугацаанд бууруулах аюултай нөхцөл байдал үүсэх, эсвэл төрийн болон төрийн бус байгууллагын

баримтлах бодлого тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ мэдэгдэхүйц хязгаарлагдсан нөхцөлд үндэсний аюулгүй байдал алдагдах эрсдэл үүснэ” хэмээн тодорхойлсон байна.

Аливаа байгууллагаа нь улс төр, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухааны технологийн хөгжил, хүн ам зүй, байгаль экологи зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээний шууд болон шууд бус нөлөөлөл дор оршин тогтнож байдаг. Эдгээр нөлөөллийн эерэг болон сөрөг талын хэрхэн хүлээн авч шийдвэрлэсэнээр тухайн байгуулагаа үүргээ амжилттай биелүүлж нэр хүнд нь өснө. Байгууллагын аюулгүй байдал, түүнийг хангах гэдэг нь үндсэн үүргээ биелүүлэхэд шууд, шууд бусаар нөлөөлж буй сөрөг. таагүй хүчин зүйл, тэдгээрийг даван туулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын цогц үйл ажиллагаа юм. Тухайн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, салбар нэгжийн харилцан ажиллагаа, уялдаа холбоо, удирдлагын арга барил, хамт олны боловсрол, эрүүл мэнд, амьдралын түвшин, мэргэжлийн ур чадвар, тогтоосон дэг журам, мэдээлэл, материаллаг үнэт зүйлсийг хэрхэн хувиарлан ашиглаж байгаа, технологийн горимыг нарийн чанд мөрдөж буй эсэх, сахилга бат зэрэг нь дотоод хүчин зүйл болно.

Цэргийн байгууллагын гадаад аюулгүй байдал, түүнийг хангах ажиллагааг дараах байдлаар авч үзэж болно.

- Улс орны эдийн засгийн хүндрэл;
- Байгалийн гамшиг *(ган, зуд, гал усны аюул, газар хөдлөлт, гоц халдварт өвчин тархах);*

> Байгууллагын нэр хүндэд санаатай болон санамсаргүйгээр халдах;

> Гадны байгууллага, хувь хүний нөлөөнд автаж, буруу үйл ажиллагаа явуулах;

> Гадны нөлөөгөөр чухал мэргэжлийн болон авьяас чадвартай хүмүүсээ алдах;

> Гадны нөлөөнд автан удирдах ажилтны гар нийлэмжтэй ажиллагаа болон хамт олны санал сэтгэгдэл алдагдах, ажлын идэвхи буурах;

> Буруу, ташаа мэдээлэл авснаас буруу шийдвэр гаргах;

> Томилогдон ирж буй офицер, ахлагч нар ажлын шаардлага, хэрэгцээг хангахгүй байх;

> Дээд шатны байгууллагаас байгууллагын үйл ажиллагаа, бодит байдлыг өрөөсгөл буруу дүгнэх;

> Техник технологийн хоцрогдолд орох;

> Бие бүрэлдэхүүний ар гэрт тохиолдсон бэрхшээлээс үүдэн таагүй байдал бий болох

Дээрх хүчин зүйлс, нөлөлөөлөөс хамгаалж үндсэн үүргээ бүрэн биелүүлэхийн тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлвэл зохино. Үүнд:

Бүх төрлийн нөөцтэй байх;

> Ангийн нэр хүндэд харш аливаа мэдээлэл, үг яриа гарсан тухай бүр нягтлан шалгах, залруулга хийх;

> Ангийн байрлалд орж гарах, гадны хүнтэй уулзах журмыг хатуу чанд сахих, бүх газрыг харуул, манааны хяналтад байлгах;

> Гэнэтийн халдлага, хулгай дээрэм гарсан үед явуулах ажиллагааг төлөвлөж, дадлага сургууль хийх, харуулын бүрэлдэхүүнийг бие хамгаалах урлагын зохих бэлтгэлтэй болгох;

> Шинээр ажилд авч буй болон томилогдож ирж буй хүний судалгааг нэн даруй хийх, ажилд авах журмаа чанд мөрдөх;

> Гадны байгууллага, хувь хүнтэй хамтарч ажиллахдаа хууль дүрэм, ангийн дотоод журмыг баримтлах;

> Ховор чухал мэргэжлийн болон урлаг, спортын авьяастай ажилтныг тухай бүр шагнаж урамшуулах, тодорхой хангалт олгох, авьяас сонирхолоо хөгжүүлэх бололцоог хангах;

> Бүх төрлийн мэдээллийг сайтар нягтлаж шалгасны дараа шийдвэр гаргах, мэдээлэл хариуцсан албан тушаалтантай байх;

> Шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, шинэ техник хэрэгслээр хангах, офицер, ахлагч нарыг төрөл бүрийн сургалтад хамруулах;

**Аюулгүй байдалд нөлөөлөх дотоод хүчин зүйл**

> Дарга /захирагч/ нарын хариуцлагагүй байдал;

> Сахилгын зөрчил гаргах

> Дутагдалтай эвлэрэх, нуун дарагдуулах

Дээрх хүчин зүйлийн нөлөөнд автахгүйн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

> Эвсэг, соёлч, боловсон харьцаатай хамт олон бүрдүүлэх зорилтыг алба салбарын дарга нарын нэн тэргүүний үүрэг болгох;

> Алба, салбарын дарга нарыг удирдахуйн ухаан, менежментийн сургалтад хамруулах;

> Бүх алба, салбар ангийн дотоод журмыг үндэслэн өөрийн дотоод журмаа боловсруулан мөрдөх;

Бүх шатны дарга захирагч нарт эрх мэдлийн хуваарилалтыг оновчтой хийж, шат дараалсан хяналтыг бий болгох;

> Хариуцлагагүй, идэвхигүй, санаачлагагүй, сөрөг сурталчилгаа хнйгчийг илрүүлэх, тэдэнтэй хүмүүжлийн тодорхой ажлыг явуулах, таслан зогсоох арга хэмжээ авах;

> байгууллагын нууцыг чанд сахих журамтай байх;

Спорт, соёл урлагийн арга хэмжээ нь хүний зөв хүмүүжил, сахилга батад эерэгээр нөлөөлдөгт ач холбогдол өгч бие бүрэлдэхүүний идэвхийг өрхүүлэх арга хэмжээг тасралтгүй авах;

Анги салбарынхаа нэр төрийг бүхнээс эрхэмлэх үзлийг бий болгоход чиглэгдсэн бүх талын арга хэмжээг авч байвал зохино гэж үзэж байна.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*академийн 821 дүгээр дамжааны сонсогч,*
*хошууч В.Хундгаа*

## ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙГУУЛЛАГАД ШИЛЖСЭН НЬ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД СӨРГӨӨР НӨЛӨӨЛӨХ НЬ

***Хураангуй.*** *Хилийн боомтын үйл ажиллагааны өнөөгийн байдлын байдлын эерэг ба сөрөг хандлага, практикт тулгамдсан байдал, цаашид шиидвэрлэх асуудлыг хөндөж тавихыг зорилоо.*

***Түлхүүр үг.*** *Шалган нэвтрүүлэх алба, иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөн.*

Дэлхий ертөнц даяаршиж байна. Даяаршлалын энэ хаялганд Монгол Улс нэгдэн нийлж, даяаршихын хэрээр улс хоорондын харилцаа өргөжин тэлж, улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн болоод бусад салбарт асар их өөрчлөлт гарч байна.

Бидний саяхан болтол амьдарч буй эрин үеийн гол асуудал “дайн болоод энхийн асуудал” гэдэг байв. Өнөөдөр бид бүхнийг айлгаж байсан аюул уламжлалт бус аюулаар солигдлоо.

Эдгээр нь хүн төрөлхтөнд бодит заналхийлэл болоод олон улсын терроризм, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүн, мал амьтны гоц халдварт өвчин, хүний болон зэвсгийн хориотой наймаа, тэсрэх дэлбэрэх бодис, хар тамхи, өвчин дэлгэрүүлэх хөнөөлт зүйлсийн зөөвөр, байгаль орчны бохирдол, байгалийн баялагийн хомсдол, хилийн зөрчлөөр илрэх болов.

Улс хоорондын харилцаа өдрөөс өдөрт улам бүр өргөжиж, олон улсын харилцааны эрчимтэй тэлэлт улс төр, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбарыг хамарч, энэ харилцаа нь хамгийн эхлээд хилийн гадаад, дотоод харилцаагаар зохицуулагдаж байна. Монгол

Улс 26 хилийн боомттой. Эдгээр хилийн боомтын гол үүргийг хил хамгаалах байгууллага саяхныг хүртэл гүйцэтгэж байлаа. Тодруулбал, хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх онцгой хийгээд чухал үүрэг тэднийх байв. Хилийн боомтын тухай хууль хэрэгжиж эхэлснээр хилийн шалган нэвтрүүлэх албаны чиг үүрэг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газарт шилжин, тус газар Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар болсон.

Тухайн үед хууль санаачлагчид шинэ хуулийг оруулж ирэхдээ гадаад худалдааг хөнгөвчлөх, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгох зорилтын хүрээнд хилийн боомтын үйл ажиллагааг сайжруулах, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, давхардлыг арилгах зорилготой гэдгийг онцолж байв.

Монгол Улсын хил хамгаалах байгууллага, эх орныхоо хил, хязгаар нутгийг хамгаалахдаа, хилийн аюулгүй байдлын чухал хэсэг болсон хилийн шалган нэвтрүүлэх албыг хамт гүйцэтгэж, энэ албыг үйл ажиллагааныхаа салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж анхаарч хилийн шалган нэвтрүүлэх албыг шинжлэх ухааны үндэстэй боловсронгуй болгох, энэ албанд шинжлэх ухаан, технологийн орчин үеийн ололт, инновацыг өргөн нэвтрүүлэх, шалгагч, удирдах бүрэлдэхүүний мэргэжил, ур чадварыг дээшлүүлэн, чадваржуулах талаар ихээхэн анхаарч ирсэн билээ.

Өнөөдөр Монгол Улс хил залгаа орших ОХУ, БНХАУ-тай байгуулсан гэрээний заалтыг үндэслэн зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлж улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон эд зүйлс, алт, мөнгө, архи, спирт, хорт бодис, түүхийн үнэт зүйлс, агнахыг хуулиар хориглосон амьтны арьс, мах зэргийг илрүүлж улсын төсөвт тодорхой хэмжээний төгрөг оруулсан тоо баримт байдаг. Улс хоорондын харилцаа, хилийн харилцаа тасралтгүй өргөжихийн хэрээр гэмт хэрэг үйлдээд улсын хилийг хуурамч бичиг баримтаар нэвтрэх, эрүүгийн хэргээс оргон зайлах, хилээр нэвтрүүлэхийг хуулиар хориглосон зүйлсийг нэвтрүүлэх, онц их хэмжээний санхүүгийн луйвар хийн, шүүхээс оргон зайлагчид, элдэв арга хэрэглэн хил нэвтрэх оролдлого хийдэг явдал сүүлийн жилүүдэд гарсаар байна.

Ийм хууль бус үйлдэлийг гаргаад байх юм бол хил хамгаалах байгууллагын нэр хүнд олон улсын хэмжээнд илт унах болно гэдгийг санаж, энэ мэт зохисгүй асуудлыг дахин хэзээ ч давтмааргүй байна.Энэ асуудал нь Хилийн шалган нэвтрүүлэх албаны хариуцлага юм.

Хилийн шалган нэвтрүүлэх албаны үүрэг, ач холбогдол өнөөгийн нөхцөлд улам бүр өсөн нэмэгдэж байгааг онцлон хэлмээр байна.

Хилийн боомтууд дээр сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл:

• Улсын хилээр нэвтрүүлэх үед үүсэх зорчигч, тээврийн хэрэгслийн бөөгнөрөл *“Өнөөгийн хэрэгцээг хийлийн боомтуудын дийлэнх хувь нь нэвтрүүлэх хүчин чадлын хувьд хангахгүй байгаагаас албаны үйл ажиллагаа, шалгалтын тоног төхөөрөмжийн хоцрогдол, боо.мтын бүтэц, орон тооны хүрэлцээгүй байдал зэргээс бөөгнөрөл үүсэх болсон ”*

• Хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны доголдол буюу хүнд суртал *"Байгууллагууд нь босоо удирдлагын тоголцоотой, харилцан уялдаа холбоогүй, зарим тохиолдолд зөрчилтэй байгаа зэргээс харагдаж байна"*

• Хилийн боомтын зарим барилга байгууламж, дэд бүтэц хараат болсон *"Цахилгааны эх үүсвэр, зам харгуй, бусад дэд бүтцийн асуудлыг төр өөрөө бус бизнесийн үйл ажиллагаа явуулдаг компаниудад даатгадаг, хамааралгүй байх тэр боло.мжийг бүрдүүлж өгч чадахгүй байна ”*

Энэ бүхнээс дүгнэхэд дэлхийн улс орны хилийн боомтууд ачааллыг хэрхэн яаж зохицуулж байна, шалган нэвтрүүлэх алба ачааллыг яаж шуурхай нэвтрүүлж байгаа болон ямар орчин үеийн техник, технологийг ашиглаж байгааг судлах, үр дүн нь манай улсын хилийн боомтыг дэлхийн жишигт хүргэх арга замыг олох, хөрш орны хилийн боомтын хүчин чадалд хүргэх үндсэн гол шаардлага гарч байна.

Иймд Хилийн шалган нэвтрүүлэх албыг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэн чадвартай, мэргэжилтэй хүний нөөцөөр бэхжүүлэх шаардлагатай гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*академийн 821 дүгээр дамжааны сонсогч,*
*дэд хурандаа Г.Энхтүвшин*

## ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТУСГАЙ САЛБАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Дэлхий дахинд болж улс хоорондын тэмцэл нь Монгол Улсын хувьд шууд бус аюул юм. Энэхүү сөргөлдөгч талуудтай манай хил залгаа улсууд холбогдож байгаа нь бид бүхнээс анхаарахгүй байж боломгүй үзэгдэл юм. Манай улсын хувьд гаднаас орж ирэх уламжлалт бус аюултай тэмцэхэд бэлэн үү, ямар хүч хэрэгсэлийг бид ашиглах вэ? гэсэн асуудал чухлаар тавигдаж байна.*

***Түлхүүр үгс.*** *Хилийн аюулгүй байдал, тусгай салбар*

2010 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь “Монгол